

Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх болон түүнтэй холбоотой журам батлах, хувьцаа худалдаж авах тухай зөвшөөрөл олгох, эргүүлэн худалдан авах хувьцааны үнийг тогтоох тухай

Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйл, 54 дүгээр зүйл, 55 дугаар зүйлийн 55.2, 55.3, 55.4, 55.7, 76 дугаар зүйлийн 76.1.7, 76.1.17 дахь хэсэг, 89 дүгээр зүйлийн 89.1, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “Говь” ХК-ийн 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 01 дугаартай Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тогтоол болон “Таван Богд Холдингс” ХХК-ийн 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн №01А-266 тоот албан бичгээр ирүүлсэн саналыг тус тус үндэслэн “Говь” ХК (Компани)-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Компанийн хэлбэр өөрчлөх тухай Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэр гарсантай холбогдуулан Компанийн хувьцаа эзэмшигчдэд 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрөөс өөрийн эзэмшлийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг Компаниас шаардах эрх үүссэнийг дурдсугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигч хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхийг хэрэгжүүлэх журмыг **Хавсралт 1**-ээр баталсугай.
3. Нэгж хувьцааг эргүүлэн худалдаж авах зах зээлийн үнийг хараат бус үнэлгээний байгууллага болох “Далайван Проперти Үнэлгээ” ХХК-аас гаргасан үнэлгээний тайлан, хувьцааны сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханш, зах зээлийн ханшийг харгалзан **259.00 (хоёр зуун тавин есөн)** төгрөг байхаар тогтоосугай.
4. Энэхүү тогтоолд заасан үнэ, журмын дагуу худалдан авахыг хяналтын багцын хувьцааг эзэмшигч “Таван Богд Холдингс” ХХК-д зөвшөөрсүгэй.
5. Өөрийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах өдрийг уг эрх үүссэн өдөр буюу **2025 оны 09 дүгээр сарын 08-ны** өдрөөр тогтоосугай.
6. Энэхүү шийдвэрийн талаарх мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн биржид 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр хүргүүлэн, хувьцаа эзэмшигчдэд Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу **2025 оны 09 дүгээр сарын 11 болон 09 дүгээр сарын 26-ны** өдрүүдэд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлан мэдэгдсүгэй.
7. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах хэвлэлийн эхийг **Хавсралт 2**-оор баталсугай.
8. Өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах хүсэлт, эсхүл Компанид хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлтийг хүлээн авах хугацааг олон нийтэд анх

20²⁵ он 09 сар 09 өдөр

Дугаар 39

Улаанбаатар хот

мэдэгдсэнээс хойш ажлын 30 өдөр буюу 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийг дуустал байхаар тогтоосугай.

9. Энэхүү тогтоолын 8-р заалтад заасан хүсэлтийг “Таван Богд Капитал ҮЦК” ХХК болон Компанид цаасан болон цахим хэлбэрээр хүлээн авахаар тогтоосугай.
10. Энэхүү шийдвэрийг сонирхлын зөрчилгүй буюу Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар баталсугай.
11. Энэхүү тогтоолыг болон Хувьцаа эргүүлэн худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэхийг Хуулийн хэлтсийн дарга /Ц.Цасчихэр/-д үүрэг болгосугай.
12. Энэхүү шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зар хүргэх журмын дагуу хүргэх, хувьцаа эзэмшигчдийн шаардах эрхийг хэрэгжүүлэх шаардлагыг хүлээн авах, тайлан, мэдээлэл хүргэн ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /М.Сэлэнгэ/-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД:



Д.ГЭРЭЛМАА

А.ЖАРГАЛМАА

Д.ХҮРЭЛБААТАР



**“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦААГ ХУДАЛДАН АВАХ ШААРДАХ ЭРХИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журмын зорилго нь “Говь” ХК (цаашид “Компани” гэх) нь хэлбэрээ өөрчлөн хязгаарлагдмал хариуцлагатай компани болохтой холбоотой Компанийн хяналтын багц эзэмшигч “Таван Богд Холдингс ХХК”-аас бусад хувьцаа эзэмшигч (цаашид “Бусад хувьцаа эзэмшигч” гэх) нь өөрийн эзэмшиж байгаа хувьцааг эргүүлэн худалдаж авахыг Компаниас шаардах эрхээ хэрэгжүүлэх, эсхүл Компанийн хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлт гаргах, Компани нь Компанийн тухай хуулийн 53, 54 дүгээр зүйлд заасан журмын дагуу шаардлага гаргасан хувьцаа эзэмшигчдээс хувьцааг эргүүлэн худалдан авахтай холбоотой үйл ажиллагааг зохицуулахад оршино.
- 1.2 Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Компанийн хэлбэрийг өөрчлөх тухай тогтоол гарсан өдөр буюу 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийг хувьцаа эзэмшигчдэд Компанид хувьцаагаа эргүүлэн худалдах шаардах эрх үүсэнд тооцно.
- 1.3 Компани хувьцаа эзэмшигчийн шаардлагаар эргүүлэн худалдаж авах хувьцааны үнийг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (Цаашид “ТУЗ” гэх)-ийн хурлаас хараат бус үнэлгээний байгууллага болох “Далайван Проперти Үнэлгээ” ХХК-аас гаргасан үнэлгээний тайлан, хувьцааны сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханшийг харгалзан **259.00** төгрөгөөр тогтоосон болно.
- 1.4 Компани нь энэхүү журмын дагуу хувьцааг эргүүлэн худалдан авах шаардлагыг ирүүлсэн хувьцаа эзэмшигчийн хувьцааг худалдаж авахыг хяналтын багц эзэмшигч “Таван Богд Холдингс” ХХК-д зөвшөөрсөн болно.

ХОЁР. БУСАД ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1 Бусад хувьцаа эзэмшигчид нь хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг Компаниас шаардах, эсхүл Компанийн хувьцаа эзэмшигчээр үлдэх эрхтэй.
- 2.2 Хувьцаа эзэмшигчид нь олон нийтийн мэдээллийн хэрэгслээр, цахим хэлбэрээр анх мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын 30 өдрийн дотор буюу 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийг дуустал өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг Компаниас шаардах, эсхүл Компанид хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлтийг энэхүү журмын 4.4-д заасан арга хэлбэрээр хүргүүлнэ.
- 2.3 Компанийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2-д заасны дагуу хувьцаагаа эргүүлэн авахыг Компаниас шаардсан, эсхүл Компанид хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлт гаргасан хувьцаа эзэмшигч нь хүсэлтдээ эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, иргэний бүртгэлийн дугаар/ регистрийн дугаар, оршин суугаа хаяг, эргүүлэн авахыг шаардаж буй

хувьцааны тоо, төрөл, эргэж холбогдох утасны (холбоо)-ны дугаар зэрэг хувийн мэдээллийг ирүүлэхийг зөвшөөрч хавсралтад заагдсан мэдээллийг бүрэн оруулах үүрэгтэй.

- 2.4 Хувьцаа эзэмшигч нь хувьцаа худалдах тухай хүсэлт, эсхүл Компанид хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлтийг бичгээр гаргахдаа холбогдох мэдээллийг үнэн зөв гаргах үүрэгтэй ба худал мэдээлэл оруулсантай холбогдуулан гарах үр дагаврыг Компани хариуцахгүй болно.

ГУРАВ. КОМПАНИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1 Компаниас шаардах эрх үүссэн талаарх шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хороо (цаашид "СЗХ" гэх)-ны "Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын дагуу олон нийтийн мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутам хэвлэгдэн гардаг сонин, орон даяар нэвтрүүлэг хүргэдэг телевиз, Компанийн өөрийн болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар тус бүр 2-оос доошгүй удаагийн давтамжтайгаар буюу 2025 оны 09 дүгээр сарын 11 болон 09 дүгээр сарын 26-ны өдрүүдэд мэдээлэх үүрэгтэй.
- 3.2 Энэ журмын 2.2-т зааснаар Компанид хүргүүлсэн хувьцаа эзэмшигчийн шаардлагыг хүлээн авч хуульд заасан хугацаанд шийдвэрлэн хариу хүргүүлэх үүрэгтэй.
- 3.3 Хувьцаа эзэмшигч Компанид эргүүлэн худалдах хувьцааны үнийг зах зээлийн үнээс бодит бус, өндрөөр үнэлэн шаардах эрхийн хүсэлтийг ирүүлсэн тохиолдолд Компани хувьцааг худалдан авахаас татгалзах эрхтэй.
- 3.4 Компани нь хувьцаа эзэмшигчийн хувийн мэдээллийг хамгаалж бусдад задруулахгүй байх үүрэгтэй.

ДӨРӨВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ШААРДЛАГААР КОМПАНИ ХУВЬЦААГ ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАЖ АВАХЫГ ШААРДАХ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ

- 4.1 Компани нь хувьцаа эзэмшигчдэд Компанид хувьцаагаа эргүүлэн худалдах эрх үүссэн тухай мэдэгдлийг энэхүү журмын 3.1-д заасны дагуу хүргэнэ.
- 4.2 Компани нь энэ журмын 1.2-д заасан өдрөөр "Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв" ХХК (цаашид "ҮЦТХТ" гэх)-өөс гаргуулан авсан хувьцаа эзэмшигчдийн тархалтын мэдээнд үндэслэн нэрсийн жагсаалтыг гаргана.
- 4.3 Өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг Компаниас шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй хувьцаа эзэмшигч нь эргүүлж авах тухай хүсэлтийг энэ журмын Хавсралт №1-д заасан маягтын дагуу, харин Компанийн хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлтэй хувьцаа эзэмшигч нь Хавсралт №2-д заасан маягтын дагуу тус тус бичгээр гаргах бөгөөд доорх хаяг руу цаасан хэлбэрээр биечлэн эсвэл цахим хэлбэрээр хүргүүлнэ.

№	Хүсэлт хүлээх авагч	Цаасан хэлбэрээр хүлээн авах хаяг	Цахим хэлбэрээр хүлээн авах хаяг
1	“Таван Богд Капитал ҮЦК” ХХК	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай-16, “Галлериа-Улаанбаатар” худалдаа үйлчилгээний төвийн зүүн жигүүр, 1 давхарт, “Таван Богд Капитал ҮЦК” ХХК	cr@tavanbogdcapital.com
2	“Говь” ХК	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3- р хороо, Үйлдвэрийн гудамж, “Говь” ХК	boardoffice@gobicashmere.com

- 4.4 Компани нь хувьцаа эзэмшигчээс 4.3-т заасны дагуу хувьцаа эргүүлэн худалдаж авах хүсэлт, эсхүл хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлтийг ирүүлсэн тухай бүр хүлээн авах, эсхүл журмын 3.3-т заасан татгалзах шийдвэрийг гарган хувьцаа эзэмшигчид бичгээр эсхүл цахимаар (Хүсэлтэд заасан цахим хаягаар) мэдэгдэнэ.
- 4.5 Компани нь хувьцаа эзэмшигчээс 4.3-т заасны дагуу хүсэлтийг хүлээн авч ҮЦТХТ рүү хүргүүлэх бөгөөд хүсэлт хүлээн авснаас хойш ажлын 30 өдрийн дотор шийдвэрлэнэ.
- 4.6 “Таван Богд Холдингс” ХХК-аас гэрээнд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хувьцаанд ногдох мөнгөн хөрөнгийг энэхүү журмын 1.3-т заасан хувьцааны үнээр тооцон гаргаж ҮЦТХТ дахь дансанд байршуулна.
- 4.7 Хувьцаа эзэмшигч нь энэхүү журмын 2.2-т заасны дагуу ажлын 30 өдрийн дотор өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг Компаниас шаардах хүсэлтийг (Хавсралт №1-д заасан маягтын дагуу) ирүүлээгүй тохиолдолд хувьцаа эзэмшигч хэвээр үлдэх саналтайд тооцно.
- 4.8 Хувьцаа эзэмшигч нь СЗХ-ны “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 6.7-д заасны дагуу хувьцаа эзэмшигчид ногдох мөнгөн хөрөнгийг 2 сарын хугацаанд өөрийн дансанд шилжүүлж авах хүсэлтээ гаргаагүй тохиолдолд бүртгэлээс хасагдсан компанийн хувьцаа эзэмшигчээр үлдсэнд тооцно.
- 4.9 Хувьцаа эзэмшигчид СЗХ-ны “Үнэт цаасны бүртгэлээс хасах тухай” тогтоол гарч, нийтэд мэдээлснээс хойш Төвлөрсөн хадгаламж дахь данснаас өөрийн арилжааны банкны данс руу шилжүүлэн авах хүсэлтийг өөрийн бүртгэлтэй үнэт цаасны компани эсхүл ҮЦТХТ рүү гаргана.

ТӨГСӨВ.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ НЬ ӨӨРИЙН ЭЗЭМШЛИЙН ХУВЬЦААГ ЭРГҮҮЛЭН АВАХЫГ
КОМПАНИАС ШААРДАХ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮСЭЛТ**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 53, 54 дүгээр зүйлд заасны дагуу өөрт үүссэн хувьцаа худалдах шаардах эрхийг хэрэгжүүлэх хүсэлтэй байгаа тул “Говь” ХК-ийн ширхэг хувьцааг нэгж үнийг 259.00 төгрөгөөр эргүүлэн авахыг Компанид буюу “Таван Богд Холдингс” ХХК-д зөвшөөрч тухайн хувьцааны мөнгийг авахыг хүсэж энэхүү шаардлагыг гаргаж байна.

Хүсэлт гаргасан хувьцаа эзэмшигчийн тухай мэдээлэл:

Иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар, хуулийн этгээд бол Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг хавсаргана уу.

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр:

Иргэний бүртгэлийн дугаар:

Хуулийн этгээдийн хувьд регистрийн дугаар:

Оршин суугаа хаяг:

Холбоо барих утас:

И-мэйл хаяг:

Төвлөрсөн хадгаламж дахь дансны дугаар*:

Эзэмшиж буй энгийн хувьцааны тоо ширхэг:

Гарын үсэг:

Хүсэлт гаргасан огноо:

**Төвлөрсөн хадгаламж дахь дансны дугаарыг мэдэхгүй тохиолдолд өөрийн бүртгэлтэй үнэт цаасны компанитай холбоо барьж асууна уу.*

Компани бөглөх хэсэг:

Хүсэлт хүлээн авагч: ☐ Таван Богд Капитал ҮЦК ХХК ☐ Говь ХК

Хүсэлт хүлээн авсан огноо:

Хүсэлт хүлээн авсан ажилтны нэр:

“ҮЦТХТ” ХХК бөглөх хэсэг:

Хүсэлт хүлээн авсан огноо:

Хүсэлт хүлээн авсан ХӨЭБКА-ны ажилтан:

Гүйлгээ хийсэн ХӨЭБКА-ны ажилтан:

Хянасан ХӨЭБКА-ны дарга:

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ НЬ ШААРДАХ ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭС ТАТГАЛЗАЖ
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИД ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧЭЭР ҮЛДЭХ
ХҮСЭЛТ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлд заасны дагуу өөрт үүссэн хувьцаа худалдах шаардах эрхийг хэрэгжүүлэх хүсэлгүй байгаа тул “Говь” ХК-ийн ногдол хувийн мөнгийг авахаас татгалзаж хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчээр үлдэхээр хүсэлт гаргаж байна.

Хүсэлт гаргасан хувьцаа эзэмшигчийн тухай мэдээлэл:

Иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар, хуулийн этгээд бол Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг хавсаргана уу.

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр:

Иргэний бүртгэлийн дугаар:

Хуулийн этгээдийн хувьд регистрийн дугаар:

Оршин суугаа хаяг:

Холбоо барих утас:

И-мэйл хаяг:

Төвлөрсөн хадгаламж дахь дансны дугаар*:

Эзэмшиж буй энгийн хувьцааны тоо ширхэг:

Гарын үсэг:

Хүсэлт гаргасан огноо:

**Төвлөрсөн хадгаламж дахь дансны дугаарыг мэдэхгүй тохиолдолд өөрийн бүртгэлтэй үнэт цаасны компанитай холбоо барьж асууна уу.*

Компани бөглөх хэсэг:

Хүсэлт хүлээн авагч: ☐ Таван Богд Капитал ҮЦК ХХК ☐ Говь ХК

Хүсэлт хүлээн авсан огноо:

Хүсэлт хүлээн авсан ажилтны нэр:

“ҮЦТХТ” ХХК бөглөх хэсэг:

Хүсэлт хүлээн авсан огноо:

Хүсэлт хүлээн авсан ХӨЭБКА-ны ажилтан:

Гүйлгээ хийсэн ХӨЭБКА-ны ажилтан:

Хянасан ХӨЭБКА-ны дарга:



“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Говь” ХК-ийн 2025 оны 09-р сарын 08-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар компанийн хэлбэрийг өөрчлөн хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох шийдвэр гарсан тул Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн 2025 оны 09-р сарын 09-ний өдрийн 39 тоот тогтоолоор Компанийн тухай хуулийн 53, 54 дүгээр зүйлд заасныг үндэслэн **бусад хувьцаа эзэмшигчид өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхийг** хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, “Таван Богд Холдингс” ХХК-д хувьцаа худалдан авах зөвшөөрөл олгосон.

Тус шийдвэрийн дагуу хувьцаа эзэмшигчдийн эрхийг хангах зорилгоор
“ХУВЬЦААГ ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАЖ АВАХ” ажиллагааг дараах байдлаар зохион байгуулж байна.

Эргүүлэн худалдаж авах нэгж хувьцааны үнэ:	259.00 төгрөг			
Шаардах эрхтэй хувьцаа эзэмшигчийн бүртгэлийн өдөр:	2025 оны 09-р сарын 08-ны өдөр			
Хүсэлт хүлээн авах хугацаа:	2025 оны 09-р сарын 11-ний өдрөөс 2025 оны 10-р сарын 23-ны өдрийг дуустал (ажлын 30 хоног)			
Бүрдүүлэх бичиг баримт:	- Шаардах эрхийг хэрэгжүүлэх хүсэлтийн маягт (Холбоос: info.gobi.mn/request), эсхүл - Хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлтийн маягт (Холбоос: info.gobi.mn/request) Хувьцаа эзэмшигч иргэн: - Иргэний үнэмлэхийн хуулбар эсхүл лавлагаа; Хувьцаа эзэмшигч хуулийн этгээд: - Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар; - Шууд төлөөлөх эрх бүхий этгээд биш бол Итгэмжлэл.			
Хүсэлт хүлээн авах хаяг:	№	Хүсэлт хүлээн авагч	Цаасан хэлбэрээр хүлээн авах хаяг	Цахим хэлбэрээр хүлээн авах хаяг Холбоо барих утас
	1	“Таван Богд Капитал ҮЦК” ХХК	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай-16, “Галлериа-Улаанбаатар” төв, зүүн жигүүр, 1 давхар	cg@tavanb ogdcapital. com 7272-7282, 94005595
	2	“Говь” ХК	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, “Говь” ХК	boardoffice @gobicash mere.com 94118277, 94995750

Жич: Шаардах эрхийн хүсэлтийг гаргаснаар хувьцаа эзэмшигчийн хувьцаанд ногдох мөнгөн хөрөнгийг тухайн хувьцаа эзэмшигчийн Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага дахь дансанд шилжүүлж, хувьцаа эзэмшигчээс хасагдсанд тооцох болно.

Нэмэлт мэдээлэл авах бол дээрх хаяг болон утсаар (Даваа-Баасан гарагт 08:00-17:00 цагийн хооронд) холбогдоно уу.



2025 он 09 сар 09 өдөр

Дугаар 40

Улаанбаатар хот

Брокерын үйлчилгээ үзүүлэх үнэт цаасны компанийг сонгох тухай

Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн харьяа нэгжүүдийн бүтэцтэй холбоотой асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалтыг удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь**:

1. Говь ХК нь Компанийн тухай хуулийн 53 болон 54 дүгээр зүйлд заасан “Хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхийг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэхтэй холбоотой брокерын үйлчилгээ үзүүлэх үнэт цаасны компаниар “Таван Богд Капитал ҮЦК” ХХК-ийг сонгосугай.
2. Энэхүү шийдвэрийг сонирхлын зөрчилгүй буюу Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар баталсугай.
3. “Таван Богд Капитал ҮЦК” ХХК-тай байгуулах гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах эрхийг Хуулийн хэлтсийн дарга /Ц.Цасчихэр/-д олгосугай.

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД



Д.ГЭРЭЛМАА

А.ЖАРГАЛМАА

Д.ХҮРЭЛБААТАР